



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 01.

Бор-Өндөр

┌
Хаврын хуурайшилт эхэлсэнтэй холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай
└

Сумын онцгой комиссын хуралдаан 2025 оны 03 сарын 13-ны өдрийн 14:00 цагт Засаг даргын Тамгын газрын ажлын байрны Иргэний танхимд 85,7 хувийн ирцтэй эхлэв.

Хуралдааныг Бор-Өндөр сумын Засаг дарга даргалж, холбогдох асуудлыг хэлэлцэв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

Бор-Өндөр сумын хэмжээнд цаг агаарын төлөв байдал 04-06 дугаар сард хур тундас маш бага хэмжээнд орж, хүчтэй шороон шуурга шуурч, салхины эрч их байх төлөвтэй байгаа тул:

1. Хаврын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан Хөдөөгийн Хүйх 5 дугаар баг, Өлгий 6 дугаар багийн малчдад ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мээдээллийг малчдад хүргэх, үүрэн холбооны сүлжээнд ордоггүй айл өрхийг тодорхойлж сумын шуурхай штабт хүргүүлэх

2. Бумбат 3 дугаар баг, Уурхайчин 4 дүгээр багийн гэр хорооллийн айл өрх бүрт объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтарч хийх

3. Бор-Өндөр 1 дүгээр баг, Холбоо 2 дугаар багийн Орон сууцны хонгилын орц, гарцыг чөлөөлүүлэх арга хэмжээг Бор-Өндөр Хот тохижилт ОНТҮГ-тай хамтарч авах, эзэнжүүлэх, Бор-Өндөр 1 дүгээр багийн багийн нутаг дэвсгэрт буй нийтийн байрнуудад галын дүгнэлтийг тус бүрт нь гаргуулах

4. Бор-Өндөр сумын Онцгой комиссын 2025 онд ажиллах төлөвлөгөөг хэлэлцэн сумын Засаг дарга, онцгой комиссын даргаар батлуулах

5. Хаврын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан болзошгүй эрсдэлд бэлэн байдлыг хангах чиглэлээр сумын Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, техник хэрэгсэлд тодотгол хийх

6. Бор-Өндөр хот тохижилт ОНТҮГ-ын цэвэрлэх байгууламжийн хийн насос эвдэрч сумын хэмжээнд аваарын байдалтай байгаа тул сумын гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 2 000 000 /хоёр сая/ төгрөг шийдвэрлэх

7. Аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулдаг Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх Бэлэн байдлын үзлэгт бэлтгэх

8. Сумын 6 багт ой хээрийн болон объектын гал түймэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах шуурхай 6 бүлгийг томилж ажиллуулах

СОНССОН НЬ:

1. Ой хээрийн гал түмрийн эрсдэлийн үнэлгээгээр Бор-Өндөр сум өндөр эрсдэлтэй үнэлэгдсэн, аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгавар гарсантай холбогдуулан хийх арга хэмжээний төлөвлөгөө гарган батлуулж, 2025 оны 03 сарын 20-ны өдөр аймгийн Онцгой комисст хүргүүлэх, хэлэлцэх асуудлын хүрээнд шийдвэрлэсэн ажлыг сумын Шуурхай штаб хариуцаж хяналт тавин шуурхай гүйцэтгэх

Онцгой комиссын дарга Г.Адъяабилэгт

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. “Хүйх” 5 дугаар багийн Засаг дарга Б.Мөнх-Оргил, “Өлгий” 6 дугаар багийн Засаг дарга Н.Отгонбилэг нарт:

1.1. Хаврын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан Хөдөөгийн Хүйх 5 дугаар баг, Өлгий 6 дугаар багийн малчдад ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мээдээллийг малчдад хүргэх,

1.2. Хүйх 5 дугаар баг, Өлгий 6 дугаар багийн үүрэн холбооны сүлжээнд ордоггүй айл өрхийг тодорхойлж 2025 оны 03 сарын 14-ний өдөр сумын шуурхай штабт хүргүүлэх

Хоёр: “Бумбат” 3 дугаар багийн Засаг дарга Д.Мөнгөнтүяа, “Уурхайчин” 4 дүгээр багийн засаг дарга Ч.Сарүүлмөнх нарт:

2.1. “Бумбат” 3 дугаар баг, Уурхайчин 4 дүгээр багийн гэр хорооллийн айл өрх бүрт объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, сургалтыг смэргэжлийн байгууллагатай хамтарч хийх

Гурав: “Бор-Өндөр” 1 дүгээр багийн Засаг дарга И.Энхтүяа, “Холбоо” 2 дугаар багийн Засаг дарга У.Пүрэвсүрэн нарт:

3.1. “Бор-Өндөр” 1 дүгээр баг, “Холбоо” 2 дугаар багийн Орон сууцны хонгилын орц, гарцыг чөлөөлүүлэх арга хэмжээг Бор-Өндөр Хот тохижилт ОНТҮГ-тай хамтарч авч ажиллах

Дөрөв: “Бор-Өндөр” 1 дүгээр багийн Засаг дарга И.Энхтүяа, Бор-Өндөр сум дахь Сум дундын Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын байцаагч, хошууч Р.Мөнхдорж нарт:

4.1. “Бор-Өндөр” 1 дүгээр багийн багийн нутаг дэвсгэрт буй нийтийн байрнуудад Бор-Өндөр сум дахь Сум дундын Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын байцаагчид хүсэлт гаргаж дүгнэлтийг байр тус бүрээр гаргуулах

Тав: Бор-Өндөр сум дахь Сум дундын Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа Г.Мөнхнаранд:

5.1. Бор-Өндөр сумын Онцгой комисс, шуурхай штабаас 2025 онд хэрэгжүүлэх ажилын төлөвлөгөөг хэлэлцүүлэн сумын онцгой комиссын дарга бөгөөд сумын Засаг даргаар 2025 оны 03 сарын 14-ны өдөрт багтаан батлуулах

Зургаа: Бор-Өндөр сумын онцгой комиссын гишүүн, байгаль хамгаалагч Б.Баярбаясгаланд:

6.1. Хаврын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан болзошгүй эрсдэлд бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд сумын ерөнхий зориулалтын Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, томилгоот техник хэрэгсэлд тодотгол хийх

Долоо: Онцгой комиссын гишүүн, ЗДТГ-ын дарга З.Ууганжаргалд:

7.1. “Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ-ын цэвэрлэх байгууламжийн хийн насос эвдэрч сумын хэмжээнд аваарын байдалтай байгаа тул сумын гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 2 000 000 /хоёр сая/ төгрөгийг шийдвэрлэх тухай сумын Засаг даргын Захирамж төлөвлөж 2025 оны 03 сарын 13-ны дотор шийдвэрлэсэн.

Найм: Онцгой комиссын гишүүн, Засаг даргын орлогч, шуурхай штабын дарга Х.Галбадрахад:

8.1. Аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулах Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх Бэлэн байдлын үзлэгт шуурхай штабын бүрэлдэхүүний гишүүдийг томилгоожуулж бэлтгэл ажлыг хангах

Ес: Онцгой комиссын гишүүн, Засаг даргын орлогч, шуурхай штабын дарга Х.Галбадрахад:

9.1. Бор-Өндөр сумын 1-6 дугаар багт ой хээрийн болон объектын гал түймэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах шуурхай 6 бүлгийг 2025 оны 03 сарын 14-ны өдрийн дотор томилж, 2025 оны 03 сарын 17-ны өдрөөс томилгоот шуурхай бүлгийг ажиллуулах

СУМЫН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

Г.АДЪЯАБИЛЭГТ

СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА БӨГӨӨД
ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

З.УУГАНЖАРГАЛ